



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/306

Номгон

Г Аймгийн төвд баригдаж байгаа дулааны Г
станц төслийн 2 дугаар хэлхээний ажилд
хяналт тавих ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн 2 дугаар хэлхээний ажилд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Наранбаяр Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн гишүүд:

М.Насанбат Баянхонгор сумын Засаг дарга

Ц.Баасанбат Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Алтангэрэл Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга

А.Цэцэнбилэг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Соронзонбаатар “Чандмань-Баянхонгор” ХК-ийн захирал

М.Мөнхбат Эрчим хүчний хяналтын Улсын ахлах байцаагч

С.Мөнхзул Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Газар зохион байгуулалт, инженерийн шугам сүлжээ, зам талбай хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга:

П.Саруулцэцэг Аймгийн Ерөнхий архитектор

2. Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Дулаан эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа 2 дугаар хэлхээний ажилд хяналт тавих, газар чөлөөлөлтийг зохион

626010849

байгуулах, иргэд, аж ахуйн нэгжийг мэдээллээр хангаж санал хүсэлтийг тусган инженерийн шугам сүлжээний ажлыг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ



جلسه محترمہ کا خلاصہ

12	3
02	
06	
0	3
11	
12	
11	

فحص

2/ م
0
6

inform

[illegible][illegible]

جائزہ یافتہ

٢٠٠٧... ٢٠٠٨

ಮೈಸೂರು

تاریخ: ۱۳۸۵/۰۵/۰۵

[illegible]

महामन्त्रि

[illegible]

۱. محضر و محضر در محضر در محضر و محضر

[illegible]

பெயர்: _____

سید محمد کمالی

626010625

